2.	ГТБ-нийг ачиж, буулгах явцад санамсаргүй тохиолдлоор асгарч ГТБ хөрсөнд нэвчих эрсдэл үүсч болзошгүй.	Асгарч гоожсон тохиолдолд нэн даруу шатахуунаар бохирдсон шороог зайлуулж хөрсийг нь эрүүлжүүлэн цэвэрлэж байгалийн жужир, шүү асгах ачилт буулгалтын хэвийн үйл ажиллагааг хангах	Вагон болон авто эсткад	300.000	Цаг тухай бүрт нь	
3.	1 болон 2-р агуулахын вагонцистерн ачих, буулгах эстакадыг хооронд нь холбох.	Төмөр замын сэлгээ хүлээхгүйгээр аль ч байрлалд байгаа вагоныг аль ч савруу буулгах болон ачих, сав сэлгэх, түргэн шуурхай ачиж буулгах нь цаг хугацааны болон эдийн засгийн хэмнэлттэй. Мөн уян шланг хэрэглэхгүйгээр зориулалтын коллектор шугам хоолойгоор буулгах нь шланг цоорч, тасарч байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхээс сэргийлнэ.	1 болон 2-р агуулах	-	5-6 сард	
ДҮН			2.400.000			

2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

д/д	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хамрах цар хүрээ	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1.	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн болон Сүмбэр сумын Засаг даргын 2020 оны А/64 тоот захирамжаар эзэмшүүлсэн мод бут тарих зориулалттай 10 га газарт шинээр нэмж 1500 мод тарих.	Зүлэг мод тарьж хашаажуулж, ойн зурвас бүхий газар болгох.	Мод тарих ажиллагааг зохион байгуулах	4.500.000	4-10 сард	MNS: 5916-2008
2.	Тарьж ургуулсан мод бут цаг тухай бүрт нь усалгаа арчилгааг нь тогтмол хийж байх, мод бут тарих мэргэжлийн байгууллагаас заавар зөвлөмжийг авч хэрэгжүүлэх.	Мод бутыг чанартай сайн тарьж ургуулж арчлах, жилийн эцэст нэгдсэн нийт тарьсан модны тоог гаргаж акт үйлдэх.	Төслийн талбайн ойр орчимд	1.050.000	4-10 сард	
3.	Тэрбум мод аяны хүрээнд модны хашаа татах	Мал амьтнаас тусгаарлах модоо хамгаалах	Төслийн талбайд	1.000.000	4-10 сард	
ДҮН			6.550.000			

3. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

д/д	Болзошгүй аюул сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах арга хэмжээ	Хамрах цар хүрээ	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1.	Болзошгүй аюул осол, техник технологи, шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул осол үүсэхээс урьдчилан сэргийлэх	2-р агуулахын галын байрны ус, хөөсний системийг туршиж хэвийн ажиллагааг хангах	Нийт ажилчид	300.000	Төслийн төлөвлөлтийн хугацаанд	Хөдөлмөр хамгаалал аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль
		Ажилчдыг хор тайлах бүтээгдэхүүнээр сар бүр тогтмол хангах	Нийт ажилчид	-	Төслийн төлөвлөлтийн хугацаанд	
		Галын аюулаас урьдчилан анхааруулсан санамж тэмдэг тэмдэглэгээний тоог нэмэгдүүлэх, гал унтраах багаж хэрэгслийн иж бүрдлийг бүрэн хангах, бэлэн байлгах.	Төслийн талбайд	500.000	Төсөл хэрэгжих хугацаанд	
		Зэрлэг өвс, ургамал хуримтлагдсанаар галын аюул учирах эрсдэл үүсч болзошгүй тул тогтмол зулгааж цэвэрлэх	Агуулахын хашаанд		Төсөл хэрэгжих хугацаанд	Галын аюулгүй байдлын тухай хууль
		Бүх төрлийн тоног төхөөрөмжүүдийн газардуулгын эсэргүүцлийг хэмжиж баталгаажуулах	Төслийн талбайд	-	Хавар, намар	

		Галын хөөсний нөөц шинэчлэх 200*8*500000	Төслийн талбайд	-		Гамшгаас хамгаалах тухай хууль
ДҮН			800.000 төгрөг			

4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө
5. Түүх, соёлын өвийн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө
6. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөг тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд төлөвлөж тусгаагүй болно.

7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

д/д	Хог хаягдлын төрөл болзошгүй сөрөг нөлөөлөл	Авах арга хэмжээ	Хамрах цар хүрээ	Нийт зардал	Хэрэгжүүлэ х хугацаа давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1.	Бүх төрлийн хатуу болон шингэн, аюултай хог хаягдал нь байгаль орчныг бохирдуулж, хүн амын эрүүл мэндэд сөргөөр муу нөлөөлдөг.	Аюултай хог хаягдал, түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах устгах болон тайлагнах бүртгэх журмын дагуу түлш, шатахуунаар бохирдсон арчих материалыг түр хадгалж аюултай хог хаягдал, цуглуулах, тээвэрлэх эрх бүхий мэргэжлийн байгууллагад шилжүүлж бүртгэл хөтлөх.	Төслийн талбайд	1.000.000	Тогтмол	MNS: 5916-2008 Хог хаягдлыг тухай хууль
2.	Энгийн болон дахивар хог хаягдал	Энгийн болон дахивар аюултай хог хаягдлыг ангилан ялгаж бүртгэн хөтөлж, хог хаягдлыг ангилан зайлуулах дахин ашиглах боломжтой хог хаягдлыг дахин дахивар авах цэгт хүргэх.	Төслийн талбайн ойр орчимд	-	Төслийн төлөвлөлтийн хугацаанд	Нүхэн жорлон угаадасны нүхний техникийн шаардлага
3.	Шингэн хог хаягдал	Бие засах газар, бохир ус хадгалах байгууламжийг стандартын дагуу ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмол хийлгэх.	Төслийн талбайд	200.000		
4.	Орон нутгийн ААНБ-тай хамтран ажиллах.	“Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ-тай хамтран гэрээ байгуулж хог хаягдалаа төвлөрсөн хогийн цэгт хаях. “Ус-Ду” ОНӨААТҮГ-тай хамтран гэрээ байгуулж Оффисын бохирын	Төслийн талбайд	1.680.000		

		бохирыг жилд 4 удаа соруулах				
ДҮН			2.880.000			

**8. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх
удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө**

д/д	Төлөвлөж буй ажил	Авах арга хэмжээ	Хамрах цар хүрээ	Нийт зардал	Хэрэгжү үлэх хугацаа давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1.	Нийт ажилчдыг эрүүл мэндийн нарийвчилсан үзлэг шинжилгээнд хамруулах.	Эрүүл аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцөлөөр бүрдүүлэх	Нийт ажилчид	-	10 сар	Ажлын байрны эрүүл орчин эрүүл ахуйн шаардлага Гамшгаас хамгаалах тухай хууль Байгаль орчны тухай хууль
2.	Говьсүмбэр аймгийн ОБГ-тай хамтран гал түймэр унтраах болон аврах тактикийн сургуулалт зохион байгуулах	Галын болон байгалийн гамшиг гэнэтийн аюул ослын үед бэлэн байх түргэн шуурхай арга хэмжээ авах нөхцөлийг бүрдүүлэх.	Төслийн талбайд	500.000	5 сар	
3.	Үйл ажиллагаа явуулахтай холбогдуулан төрийн байгууллагын хяналт шалгалт, орон нутгийн Засаг захиргаанаанаас тавьж буй шаардлага зөвлөмжийг биелүүлж хамтран ажиллах.	Төрийн хяналт шалгалт албан шаардлага, заавар зөвлөмжийг дагаж мөрдөх биелүүлэх. /Аж ахуйн нэгж албан байгууллагуудыг хамарсан мод тарих, их цэвэрлэгээ хийх, бүтээн байгуулалтанд оролцох/	Аймаг орон нутагт	-	Тухай бүрт нь	
4.	Нийт ажилчдад Байгаль орчны тухай хууль, мод, бут тарих сургалтыг зохион байгуулах.	Нийт ажилдыг сургалтанд хамруулж анхан болон ахисан түвшний мэдлэгтэй болгох.	Төслийн талбайд	300.000		
5.	Байгаль орчны аудит хийлгэх.	Байгаль орчны аудит хийлгэж байгаль орчинд тулгарч буй шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх.	Төслийн талбайд	5.000.000		
6.	Газрын тосны бүтээгдхүүний чиглэлээр мэргэжил олгох сургалтыг зохион байгуулах.	Ачигч, буулгагч нарыг сургалтанд хамруулж мэргэжлийн үнэмлэх сертификаттай болгох.	Ажилчид	-		
ДҮН			5.800.000			

9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

д/д	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж	Шаардагдах зардал	Баримтлах стандарт, аргачлал
1. Агаарын чанарын хяналт шинжилгээ					
1.	Агаарын бохирдлын шинжилгээ хийлгэх	Төсөл хэрэгжих талбайд хяналтын цэг сонгох /вагон эсткад ачиж буулгах талбайн ойр орчим/	Агаарын найрлага жилд 2 удаа	500.000	MNS: 4585-2007 агаарын чанар техникийн ерөнхий шаардлага
2.	Агаарын тоосны шинжилгээг мэргэжлийн байгууллагаг хийлгэх дуу, шуугиан, чичэргээ гэх мэт		Тоосны хяналт: Төслийн талбайд 2 цэгт жилд 2 удаа	500.000	MNS: 5885-2008
2. Усны хяналт шинжилгээ					
1	Усны ерөнхий шинжилгээ: /рН, Хатуулаг, хлор, төмөр, нитритийн ион, аммонийн ион, кальци, магни, фтор Нян судлал: Гэдэсний савханцар, нян бактерийн ерөнхий тоо	Оффисын худаг болон агуулахын худагнаас	Ерөнхий үзүүлэлт, нян судлал жилд 2 удаа	500.000	Усны дээжийн сав 500/мл MNS:0900-2005 MNS:0900-2005 ISO-4867-1999 Дээжийг боловсруулах хадгалах зөвлөмж
3. Хөрсний хяналт шинжилгээ					
1	Хөрсний хими, фикик, шинж чанарыг тодорхойлох: Хүнд металл: Кадми, Хар тугалга, Мөнгөн ус, Хром, Стронци	Ачилт буулгалтын талбайн ойр орчмын газраас	Хөрсний хими, фикик шинж чанарыг жилд 2 удаа	750.000	MNS:5850-2008 Хөрс бохирдуулагч бодис зөвшөөрөгдөх дээд хэмжээ
2.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан агаар ус хөрсний шинжилгээг байгаль орчны итгэмжлэгдсэн лабораториар хийлгэж хүнд металлын агууламжийг тодорхойлуулах.	Төсөл хэрэгжих талбайд хяналтын цэг сонгох	Жилд 1 удаа	750.000	
ДҮН			3.000.000		

10. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

д/д	БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацаа	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
1.	БОАЖЯ, Говьсүмбэр аймгийн Байгаль орчины газар	БОМТөлөвлөгөөний тайланг хянуулах, хэлэлцүүлэх, батлах.	Тухайн жилийн байгаль орчны менежментийн тайлан	2026.11.01 өдрийн дотор	БОМТайланг танилцуулж батлах	Говьсүмбэр аймгийн БОАЖГ

11. Менежментийн төлөвлөгөөний төсвийн ерөнхий нэгтгэл

№	Төлөвлөгдсөн ажил	Төсөвлөсөн зардал
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	2.400.000
2	Нөхөн сэргээх төлөвлөгөө	6.550.000
3	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	800.000
4	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	2.880.000
5	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	5.800.000
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	3.000.000
НЭГДСЭН НИЙТ ДҮН		21.430.000

**14. “ЗУУННАЙМАН ОЙЛ” ХХК-ИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЯНАЛТЫН ХУУДАС**

**НЭГ. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ХУУЛИЙН ЭТГЭЭД,
ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ МЭДЭЭЭЛЭЛ**

д/д	Мэдээллийн төрөл	Мэдээлэл
1.1	7. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийн нэр	“Зууннайман Ойл” ХХК
	8. Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн дугаар	9011316010
	9. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэл	ГТБ-г импортлох, хадгалах, бөөнөөр борлуулах
	10. Аж ахуйн нэгжийн харьяаллын хаяг	Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 26-р хороо, Paradise plaza 16 давхар
	11. Захирлын нэр, утас, цахим шуудангийн хаяг	О.Сайнбилэг, 88108075, Sainbileg@108oil.mn
	12. Холбогдох мэргэжилтний нэр, утас, цахим шуудангийн хаяг	Д.Сэргэлэнцогт 85082400 Sergelentsogt@108oil.mn
1.2	1. Төслийн нэр	“Нефть бүтээгдэхүүний гаалийн баталгаат агуулах”
	10. Төслийн харьяаллын байршил	Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 1-р баг, Ганзам гудамж 1001Б тоот.
	3. Төслийн ангилал, Үйлдвэр	ГТБ-ний агуулах
	9. Төсөл эхэлсэн огноо	2019 он
	10. Төсөл хэрэгжих хугацаа	
	11. Үйлдвэрийг хүлээж авсан улсын комиссын дүгнэлт	№ 02/99/2012
	12. ТЭЗҮ баталсан огноо	2018 он
	13. Урьд оны бүтээгдэхүүний нийт хэмжээ /дундаж/	

ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ОЛГОГДДОГ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ, ДҮГНЭЛТ, ЛАВЛАГААНЫ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

д/д	Мэдээллийн төрөл	Мэдээлэл
2.1	1. Үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл Дугаар Хүчинтэй хугацаа Талбай	2. Импортын, 2. Бөөний 153, 154 2027-7-10
	11. Тусгай зөвшөөрлийн төрөл /химийн бодис ашиглах, тэсрэх дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн дагуу олгосон холбогдох зөвшөөрөл бусад баримт бичиг/ Дугаар Хүчинтэй хугацаа	Шаардлагагүй
	12. Химийн бодисын агуулгад хийсэн мэргэжлийн хяналтын газрын дүгнэлт	Шаардлагагүй
	13. Галын дүгнэлтийн огноо, дугаар	2025-05-08 №0006267
	14. Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний огноо, баталсан хуулийн этгээд	2023 он, БОАЖЯ-ны ерөнхий шинжээч Ц. Уранчимэг
	15. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний огноо, баталсан хуулийн этгээд	2023 он, БОАЖЯ-ны ерөнхий шинжээч Ц. Уранчимэг
	16. Ус ашиглалтын дүгнэлтийн огноо	2025-05-28
	17. Тухайн жилийн батлагдсан үйлдвэрлэлийн төлөвлөгөөний огноо	
	18. Тухайн жилд баримтлаж ажиллах стандартын дугаар • Үндэсний Олон улсын	MNS 5746:2007, MNS 4633: 2006, MNS 0216:2017, БНБД 21-03-04

ГУРАВ. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛ, ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

д/д	Мэдээллийн төрөл	Мэдээлэл
3.1	3. Тухайн жилд ашиглах химийн бодисын нэр, хэмжээ /хэмжих нэгж/ гхимийн бодис, бүтээгдэхүүнээс гарах сав баглаа боодлын хэмжээ	Хамааралгүй
	4. Химийн бодисын эрсдлийн менежментийн төлөвлөгөө	Хамааралгүй
3.2	15. Шатах тослох материалын нэр хэмжээ /хэмжих нэгж/ агуулах байгаа эсэх 16. Тэсрэх, дэлбэрэх бодисын нэр хэмжээ /хэмжих нэгж/ агуулах байгаа эсэх	Дизелийн түлш нийт 33000 м3-н агуулах
3.3.	1. Тухайн жилийн хог хаягдлын жилийн дундаж хэмжээ /хэмжих нэгж/ - Ахуйн хог хаягдал /хатуу, шингэн/ - Үйлдвэрийн хог хаягдал /хатуу, шингэн/ - Аюултай хог хаягдал	Ахуйн хог хаягдал 10 тн
	2.Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх тухайн жилийн арга хэмжээний төсөв	2.880.00 төгрөг

**ДӨРӨВ. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ТУХАЙН ЖИЛИЙН ТӨСӨВ**

д/д	Мэдээллийн төрөл	Мэдээлэл
4.1	8. Тухайн жилийн байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний нийт төсөв	21.430.000
	9. Нөлөөллийг зайлуулах арга хэмжээний төсөв /технологийн зөв шийдэл/	Дотоод нөөц бололцоо
	10. Нөлөөллийг бууруулах арга хэмжээний төсөв	2.400.000
	11. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төсөв	-
	12. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төсөв	200,000
	13. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөв	5.800.000
	14. Тухайн жилийн орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн нийт төсөв	21.430.000

ТАВ. МЕТА МЭДЭЭЛЭЛ

д/д	Мэдээллийн төрөл	Мэдээллийг бүрэн тусгасан эсэхийг шалгах багана
5.1	Зурган мэдээлэлд тусгах мэдээлэл 10. Ажилчдын байр, оффис 11. Дэд бүтэц (зам, өндөр хүчдэл, цахилгаан сүлжээ, шугаман хоолой, станцын байршил, хашаа, тусгаарлагч, үерийн хамгаалалтын далан, аянга зайлуулагч гэх мэт) 12. Хог хаягдлын цэгийн байршил 13. Хог хаягдлын агуулахын байршил 14. Хог хаягдлын далан 15. Химийн бодисын агуулахын байршил 16. Орчны хяналт шинжилгээний дээж авах хяналтын цэгийн байршил 17. Гүний худгийн байршил 18. Дүйцүүлэн хамгааллын байршил	

**ЗУРГАА. ТУХАЙН ЖИЛИЙН АРГА ХЭМЖЭЭНЭЭС БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ
НӨЛӨӨЛЛИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ХЯНАЛТЫН ХУУДАС**

Нөлөөллийн ангилал	А. Тооцсон эсэх	Б. Нөлөөллийн цар хүрээг тодорхойлсон эсэх	В. Нөлөөл-лийн эрчмийг тодорхойлсон эсэх	Г. Нөлөөллийн үргэлжлэх хугацааг тодорхойлсон эсэх	Дүгнэлт
12.1.Хөрсөнд үзүүлэх нөлөөлөл - Бохирдуулах - Эвдэх - Доройтуулах	тодорхойл сон	тодорхойлсон	тодорхойлсон	тодорхойлсон	
12.2.Гадаргын болон гүний усанд үзүүлэх нөлөөлөл - Бохирдуулах - Нөөцийг бууруулах	тодорхойл сон	тодорхойлсон	тодорхойлсон	тодорхойлсон	
12.3. Амьтан, ургамалд үзүүлэх нөлөөлөл - амьдрах орчинг хуваах - амьдрах орчинг доройтуулах - амьдрах орчинг хомсдуулах - нөөцийг бууруулах	тодорхойл сон	тодорхойлсон	тодорхойлсон	тодорхойлсон	
12.4. Агаарт үзүүлэх нөлөөлөл - Бохирдуулах - тоос	тодорхойл сон	тодорхойлсон	тодорхойлсон	тодорхойлсон	тодорхойлсон

**ДОЛОО. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ДҮН
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЯНАЛТ**

Тухайн жилийн байгаль хамгаалах арга хэмжээний чиглэл	А. Тоо	Б. Шалгуур үзүүлэлтийг тогтоосон эсэх	В. Шалгуур үзүүлэлтийн хэмжих нэгжийг тогтоосон эсэх	Г. Дүгнэлт
14.1. Нөлөөллөөс зайлсхийх арга хэмжээ		Тийм	Тийм	
14.2. Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	5	Тийм	Тийм	
14.3. Нөхөн сэргээлтийн арга хэмжээ -техникийн/ га эзэлхүүн -биологийн /га		Тийм	Тийм	
14.4. Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээ	-	-	-	
6.5 Төслийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах арга хэмжээ	1	Тийм	Тийм	

ХАВСРАЛТ



**“ЗУУННАЙМАН ОЙЛ” ХХК-ИЙН ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
СҮМБЭР СУМЫН НУТАГТ ОРШИХ “ЧОЙР ЛОГИСТИК ТӨВ”
ТӨСЛИЙН ҮЙЛ**

**АЖИЛЛАГААНД ХИЙСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ НИЙЦЭЛ
БА ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН**

/ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ/



**“ЗУУННАЙМАН ОЙЛ” ХХК-ИЙН ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН СҮМБЭР СУМЫН
НУТАГТ ОРШИХ “ЧОЙР ЛОГИСТИК ТӨВ” ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ХИЙСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ НИЙЦЭЛ БА ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН
/ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ/**

Байгаль орчны аудитын тайлан боловсруулсан:

“БАДАМЛИГ” ХХК

Гүйцэтгэх захирал:



С.Түмэнбаяр

Улаанбаатар хот
2026 он

БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТЫН ТАЙЛАНГИЙН НЭГДСЭН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ БОЛОВСРУУЛАХ ҮЕ ШАТ

1. НЭГДСЭН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ БОЛОВСРУУЛСАН АРГАЧЛАЛ


Аудитын багийн гишүүн бүр хариуцсан ажил үүргийнхээ хүрээнд асуулгын хуудас, нийцэл, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн жагсаалтын дагуу гүйцэтгэсэн ажил, тэмдэглэл, нотлон баталгаажуулсан баримтад тулгуурлан тус тусын хариуцсан чиглэл чиглэлээр хараат бусаар бие даан үнэлсэн байгаль орчны нийцлийн болон гүйцэтгэлийн аудитын үнэлэмж, тухайн хэсгүүдийн дүгнэлт, зөвлөмжийг боловсруулсан болно.

Багийн ахлагч гишүүн нэг бүртэй хамтран сууж ярилцан нэгдсэн дүгнэлт, зөвлөмжид оруулах үнэлэмжүүдээр санал солилцон зөвшилцөв. Багийн гишүүдийн гаргасан санал болон тэдгээрийн аудитын үнэлэмжид тулгуурлан нэгдсэн дүгнэлт, зөвлөмжийн төслийг боловсруулав.


Багийн гишүүдийн 2026 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн хурлаар хэлэлцэн тайлангийн нэгдсэн дүгнэлт, зөвлөмжийг эцэслэн боловсруулав.

2. АУДИТЫН НЭГДСЭН ДҮГНЭЛТ

1. Байгаль орчны нийцлийн 94 шалгуур үзүүлэлтийн 73 % нь бүрэн нийцэлтэй буюу эрсдэлгүй, 2 % нь бүрэн бус нийцэлтэй боловч эрсдэл бага, 15 % нь бүрэн бус нийцэлтэй буюу эрсдэл дунд, 10 % нь үл нийцэлтэй буюу эрсдэл их байгаа нь нэгдсэн дүнгээр “ХАНГАЛТТАЙ” гэж дүгнэгдэж байна.




Зураг 1. Нийцлийн нэгдсэн үнэлэмж




Зураг 2. Хуулийн нийцлийн нэгдсэн үнэлгээ

2. Байгаль орчны гүйцэтгэлийн 169 шалгуур үзүүлэлтийн 78 % нь биелсэн, 22 % нь биелээгүй байгаа нь нэгдсэн дүгнэлтээр “ХАНГАЛТТАЙ” гэж дүгнэгдэж байна.



Зураг 3. Гүйцэтгэлийн үнэлгээ



Зураг 4. Гүйцэтгэлийн нэгдсэн үнэлгээ

3. Байгаль орчныг хамгаалахтай холбоотой хууль эрх зүйн нийцлийн хувьд Газар, хөрс, нөхөн сэргээлттэй холбоотой хууль, Хог хаягдлын менежментийн асуудалтай холбоотой үл нийцэл хамгийн өндөр хувьтай байна.
4. Байгаль орчныг хамгаалах чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийн хувьд хог хаягдлын менежмент, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэлд хамгийн өндөр хувьтай үл нийцэл байна.

3. АУДИТЫН НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ

“Зууннайман ойл” ХХК-ийн “Чойр логистик төв”-ын үйл ажиллагаанд Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10¹ зүйлд заасны дагуу хийсэн байгаль орчны аудитын ажлын үр дүнд доорх дүгнэлт, зөвлөмжүүдийг өгч байна. Эдгээр дүгнэлтийн ололт, амжилтыг агуулахын цаашдын үйл ажиллагаанд хэвшүүлэх, дутагдал доголдлыг засч залруулах, зөвлөмжүүдийг зайлшгүй хэрэгжүүлбэл зохино.

Монгол улсын байгаль орчны хуулиуд, эдгээр хуулийн дагуу гарсан дүрэм, журмуудын зүйл, заалтуудын хэрэгжилтийг дүгнэхээр урьдчилан бэлтгэсэн шалгуур үзүүлэлт бүхий хүснэгтийн асуулгын дагуу үнэлж тодорхойлов. Үүнд:

3.1. Ажлын байран дээр бэлэн байх баримт бичгийн бүрдэлт, тэдгээрийг ажлын хэрэгцээнд ашиглах байдал болон хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих байгууллагын дотоод хяналтын чиглэлээр:

3.1.1. Төслийн талбайд газрын төлбөр, үс ашигласны төлбөр, үс бохирдуулсны төлбөр, агаарын бохирдлын төлбөр гэх мэт төлбөр төлсөн баримтууд байхгүй байсан ба цаашид төслийн талбайд хуулбар хувийг байлгахад анхаарах нь зүйтэй.

3.1.2. Төслийн экологи, аюулгүй байдлын менежментийг зохицуулах дээрхи үндсэн баримт бичгүүдийг төслийн талбай дээр цаашид байнга байлгахын зэрэгцээ тэдгээртэй танилцаж, өгсөн зөвлөмж, шаардлага хэрхэн хэрэгжиж байгаад удирдлагаас хяналт тавьж, үнэлэлт дүгнэлт өгөхийн тулд агуулахын захиргааны нэг ажилтаны ажлын байрны тодорхойлолтод дараах асуудлыг хариуцуулахаар тусгаж өгөх Үүнд:

- Дээрхи баримт бичгүүдэд тодорхойлсон үүрэг, хариуцлага, зөвлөмж, хийвэл зохих ажил, арга хэмжээний гол заалт бүрийг агуулахын хэмжээнд хариуцан гүйцэтгэх ажилтан, биелэлтэд хяналт тавих албан тушаалтан бүрийг томилон хуваарилж оноосон агуулахын нэгдсэн календарчилсан жилийн төлөвлөгөөг боловсруулж, агуулахын удирдлагаар батлуулан, биелэлтийг хугацаанд нь гаргуулж, нэгтгэн дүгнэж нийтэд мэдээлж байх
- Дээрхи баримт бичгүүдийг ажилтан бүрт ил тод, нээлттэй байлгаж, үзэж танилцах боломж олгон, зохих мэдээллээр хангахаас гадна эдгээр бичиг баримтын хадгалалт хамгаалт, бүрэн бүтэн байдлыг хянан хариуцах (*Байгаль орчныг хамгаалах тухай хууль. 31 дүгээр зүйлийн 1.1*);

3.1.2. “Чойр логистик төв” төслийн БОННУ-ний тайланг ажлын байранд нээлттэй байлгаж, үнэлгээний тайлангийн зөвлөмж, арга хэмжээ бүрийг хариуцах эзэнтэйгээр төлөвлөн гүйцэтгэлийг хянах тухайн оны календарчилсан төлөвлөгөөг 12 сараар графикаар гаргаж сар, улирлаар дүгнэж, ажилтнуудтай биелэлтийн хариуцлага тооцох тогтолцоог бий болгон агуулахын үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, байгаль хамгаалах үүргээ биелүүлэх (*Байгаль орчныг хамгаалах тухай хууль. 31 дүгээр зүйл*);

3.1.3. Байгаль орчны багц хууль, байгаль орчны менежментийн төлөвлөгөө, байгаль

орчны стандарт, хэм хэмжээ, дүрэм, журам, ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй

байдал, эрүүл ахуйн стандартын хэрэгжилтэд хяналт тавих байгаль орчны ажилтныг ажиллуулан ахиц дэвшил, алдаа оноог улирал, хагас жил, бүтэн жилээр дүгнэж, төлөвлөгөөний хэрэгжилт, гүйцэтгэлд байгаль орчны дотоод аудит хийж, гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлж байх (*Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 31 дүгээр зүйлийн 1.2; 1.7*);

3.1.4. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг жил бүр боловсруулан батлуулж, мөрдөж ажиллах (*БОНБҮТХ-9 дүгээр зүйл, 9.3*)

3.1.5. Төслийн талбайд “Зууннайман ойл” ХХК-ийн Газрын тосны бүтээгдэхүүний агуулах, Гаалийн хяналтын талбай зэрэг хоёр тусдаа нэгж үйл ажиллагаа явуулж байгаа ба байгаль орчны чиглэлээр нэгдсэн нэг менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж хамтран ажилладаггүй байдалтай байна. Иймд цаашид “Чойр логистик төв” төслийн хүрээнд дээрхи нэгжүүд Байгаль орчны менежментийг хамтран хэрэгжүүлэх, Байгаль орчны чиглэлээр хэрэгжүүлж буй үйл ажиллагаануудаа нэгдсэн зохион байгуулалтанд оруулах нь зүйтэй байна.

3.1.6. Байгаль орчны аудитыг хуульд заасан хугацаанд гүйцэтгүүлж байх. (*БОХТХ-10’ дүгээр зүйл, 10.1*)

3.2. Газрын гадарга, хэвлийн ашиглалт, хамгаалалтын чиглэлээр:

3.2.1. Тухайн жилийн менежментийн төлөвлөгөөнд агуулахын эдэлбэр газрын гадаргад гарсан өөрчлөлтийг жил бүр тодорхойлж, хариу авсан арга хэмжээний үр дүнг тайлагнах /*Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А-618 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”/.*

3.2.2. Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг хуульд заасан хугацаанд гүйцэтгэж байх /*ГТХ 58 дугаар зүйл, 58.5/.*

3.2.3. Газрын төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлж, төлбөрийн баримтын хуулбарыг ажлын байранд байлгах /*ГТХ 7 дугаар зүйл, 7.1, 35-р зүйл, 35.3.3, ГТТХ 9 дүгээр зүйл 9.2/.*

3.2.4. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан цэгүүдэд, төлөвлөсөн хугацаанд хэмжилт, дээжлэлтийг хийж байх

3.3. Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр:

3.3.1. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан цэгүүдэд, төлөвлөсөн хугацаанд хэмжилт, дээжлэлтийг хийж байх

3.3.2. Хуурайшилт ихтэй үед тоосжилт үүсгэх зам, талбайд усалгаа хийх

3.4. Гадаргын болон газрын доорхи ус ашиглалт, хамгаалалт, бохир ус зайлуулах, эргүүлэн ашиглах менежментийн чиглэлээр өгөх зөвлөмж

3.4.1. Унд ахуйн усны эх үүсвэр гүний худгуудад эрүүл ахуйн санамж байршуулах, бохирдлоос сэргийлэх арга хэмжээ авах /*УТХ 31-р зүйл 31.3, 31.4/*

3.4.2. Ус ашигласны төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлж, төлбөрийн баримтын

хуулбарыг ажлын байранд хадгалах /БНАТТХ 6 дугаар зүйл 6.1 , УТХ 31 дүгээр зүйл 31.1/

3.4.3. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан цэгүүдэд, төлөвлөсөн хугацаанд хэмжилт, дээжлэлтийг хийж байх

3.5. Хөрсөн бүрхэвчийн хамгаалалт, бохирдлоос сэргийлэх ажлыг сайжруулах чиглэлээр өгөх зөвлөмж

3.5.1. Мод тарьж буй 10 га талбайд ногоон байгууламжийг үе шаттайгаар бий болгох ажлыг жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөндөө тусган мөн тухайн орчинд тохирсон ургамал тариалж арчилгаа, ургалтанд онцгой анхаарч, үр дүнг сайжруулах илүү дэвшилтэт арга замыг хэрэгжүүлэх /Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль 7.2.4/;

3.5.2. Төслийн талбайн доторх болон гаднах замыг тээврийн аюулгүй байдал, тоосны дэгдэлттэй уялдуулан хурдны хязгаарлалтын тэмдгийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах /Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль, 6.1.6 болон 6.2.1/;

3.5.3. “Монгол улсын стандарт Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850 : 2008” -ын хэрэгжилтийг хангаж ажиллах, ялангуяа газрын тосны бүтээгдэхүүн зөвшөөрөгдөх дээд хэмжээ /хүлцэх агууламж/ 0,2 мг/кг/ -г зохих хэмжээнд байгаа эсэхэд эрсдэлтэй байршлын хөрсөнд химийн шинжилгээ хийлгэж дүгнэлт гаргуулж байх;

3.5.4. Газрын тосны бүтээгдэхүүн хөрсөнд алдагдсан үед хусаж авах, саармагжуулах, цэвэрлэх арга хэмжээ авах, асгаралтын үед ашиглах шаардлагатай багаж материалыг бэлтгэх;

3.5.5. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан хөрсний мониторингийн цэгүүдэд хяналт шинжилгээний ажлыг тогтоосон хугацаанд гүйцэтгэж байх.

3.6. Ургамлан нөмрөг, амьтны аймгийг хамгаалалтыг сайжруулах чиглэлээр:

3.6.1. Мод тарьж буй талбайн арчилгааг тогтмол хийх;

3.6.2. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан хөрсний мониторингийн цэгүүдэд хяналт шинжилгээний ажлыг тогтоосон хугацаанд гүйцэтгэж байх.

3.7. Хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр:

3.7.1. Хог хаягдлыг ангилах, ачих, цуглуулах технологид нийцсэн, галд тэсвэртэй материалаар хийгдсэн, салхиар тархах, хур тунадасны ус хуримтлагдах, шүүрэл ялгарахаас сэргийлсэн шаардлага хангасан зориулалтын тагтай хогийн савтай болж энгийн хатуу хог хаягдлаа ангилан хадгалж, ил задгай талбайд хог тархахгүй байх нөхцлийг бүрдүүлэх /ХХТХ 15 дугаар зүйл/;

3.7.2. Хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэхдээ хуулиар хориглосон үйл ажиллагааг бүрэн мөрдөх, хөрс бохирдуулах нүхэн жорлон ашиглахгүй байх /ХХТХ 10 дугаар зүйл, 10.3/;

3.7.3 “Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам”-ын дагуу агуулах, ахуйн хүрээнд үүсэх энгийн хог хаягдлаа ангилан ялгаж хогийн төвлөрсөн цэгт хүргүүлэх ажлыг зохион байгуулах

3.7.4. Тогтоосон, зориулалтын цэгээс бусад газарт хөрсийг хог хаягдлаар бохирдуулахгүй, хог хаяхгүй байх */Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль, 7.2.2/;*

3.7.5. Нийт ажилтан албан хаагчдын дунд хог хаягдлын менежментийн талаар сургалт явуулах */Хог хаягдлын тухай хууль, шинэчилсэн найруулга, 2017 он, 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг/;*

3.7.6. Хог хаягдлын төлбөрийг гэрээний хугацаанд төлөх, төлбөр төлсөн баримтын хуулбарыг ажлын байранд бэлэн байлгах */ХХТХ, 10 дугаар зүйлийн 10.2.7. дахь хэсэг/;*

3.7.7. Аюултай хог хаягдал, түр хадгалах, тээвэрлэх, дахин боловсруулах устгах болон тайлагнах бүртгэх журмын дагуу түлш, шатахуунаар бохирдсон арчих материалыг түр хадгалж эрх бүхий мэргэжлийн байгууллагад өгөн бүртгэл хөтлөх

3.8. Орон нутагтай хамтран ажиллах, сүм, орон нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх чиглэлээр:

3.8.1. Байгаль орчны менежментийн жил жилийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн явц болон хамтын ажиллагааны гэрээний биелэлт, үр дүнгийн талаар сүм, багийн иргэдэд бүтэн жилээр тайлагнаж, санал хүсэлтийг сонсож, хариу арга хэмжээг авч мэдээлж байх.

**БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТЫН ЗӨВЛӨМЖӨӨС ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ
ХАРИЛЦАН ЗӨВШИЛЦӨЖ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ
ТӨЛӨВЛӨГӨӨ**

д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээний нэр	Хугацаа, он	Шаар- дагдах зардал, сая төгрөг	Зөвлөм- жийн дугаар
1	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг жил бүр БОННУ-ний тайланд тусгагдсан чиглэл хуваарийн дагуу гүйцэтгэх	2025-2026	40.0	2.4, 3.1, 4.3, 5.5, 6.2
2	Хуулийн шаардлага хангасан зориулалтын тагтай хогийн савтай болж энгийн хатуу хог хаягдлаа ангилан хадгалан ил задгай талбайд хог тархахгүй байх нөхцлийг бүрдүүлэх	2025-2026	5.0	7.1
3	Нийт ажилтан, албан хаагчдад хог хаягдлын менежментийн чиглэлээр сургалт явуулах	2025-2026	15.0	7.5
4	Сум, орон нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлэх	2025-2026	Үйл ажиллагаан ы зардалд тусгах	11.1

Тайлбар: Байгаль орчны аудитын зөвлөмжид байгаа хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаагүй заалтуудыг жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгах буюу үүрэг хариуцлагаа чангатгах үндсэн дээр хэрэгжүүлж тайлан мэдээг тухай бүр гаргаж холбогдох байгууллага, олон нийтэд сурталчилж байх нь зүйтэй

